

ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ХӨТӨЛБӨРӨӨР ЕСҮСТЭЙ АДИЛ ӨСӨЖ ХӨГЖИХ НЬ

Хүүхэд, өсвөр үеийнхний хөтөлбөр нь Хүүхдийн Хэсгийн үйл ажиллагаанд оролцож, зорилго тавьж, сайн мэдээний талаар суралцсанаар Есүс Христтэй илүү адилхан болоход чамд туслах болно. Энэ нь мөн шинэ зүйлийг туршиж, цагийг зугаатай өнгөрүүлэхэд чамд тусална. *Хүүхдүүдэд зориулсан удирдамж* нь чамд эхлэхэд туслах болно. Хэрэв чамд энэ товхимол байхгүй бол Хүүхдийн хэсгийн багшаасаа аваарай.



Чи сайн мэдээний талаар илүү ихийг мэдэж авснаар сүнслэг байдлаар өсөж хөгжиж чадна.



Чи бусадтай нөхөрлөснөөр нийгмийн хувьд өсөж хөгжиж чадна.



Чи дасгал хөдөлгөөн хийж, ур чадвараа хөгжүүлснээр бие махбодын хувьд өсөж хөгжиж чадна.



Чи шинэ зүйлийг сурч мэдсэнээр оюун санааны хувьд өсөж хөгжиж чадна.



“Есүсийн мэргэн ухаан, бие хаа өссөөр байсан агаад Бурханы хийгээд хүмүүсийн таалал Түүнд байлаа”.

(Лук 2:52)